**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 18 өдөр                    Дугаар А/24                    Номгон

Аймгийн Хил хамгаалах туслах хүчний 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хил хамгаалах туслах хүчний 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА                                        Д.МӨНХСАЙХАН

642310059

Аймгийн Засаг даргын ... оны ... дугаар сарын
....-ны өдрийн .... дугаар захирамжийн хавсралт

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО: Хилийн тухай хуулийн 7 дугаар бүлэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж, хилчид, ард иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хил хамгаалалтад туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

| д/д | Үйл ажиллагааны чиглэл | Хугацаа | Төсвийн зардал /сая төгрөг/ | Хариуцах байгууллага | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 |
| **Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар:** | | | | | |
| 1 | “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн ажлыг зохион байгуулах, салбар зөвлөлийн ажлыг удирдлагаар хангах | Жилдээ | - | Аймаг, сумдын ЗДТГ | |
| 2 | Хилийн сумдын ХХТХСЗ, гишүүдийн цугларалтыг зохион байгуулах | Хагас жилдээ | - | Хилийн сумдын ЗДТГ, Хилийн 0166 дугаар анги | |
| 3 | Аймаг, сумдын ХХТХЗ, салбар зөвлөл, гишүүдийг үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулах | XI сард | - | Хилийн 0166 дугаар анги | |
| 4 | Монгол Улсын Хилийн тухай хуулийн хэрэгжилт, хилийн нөхцөл байдал, хил хамгаалалтын дүн, застав, харуул, хилчдийн үйл ажиллагаа, хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн ажлыг ХХТХЗ-ийн даргад танилцуулах | Хагас жилдээ | - | Хилийн 0166 дугаар анги | |
| 5 | Хил орчмын ард иргэдтэй гурвалсан гэрээ байгуулж хилийн бүсэд мал өвөлжүүлэх асуудлыг хамтран шийдвэрлэх | Жилдээ | | Аймгийн ЗДТГ, Хилийн 0166 дугаар анги | |
| 6 | Хилч эх оронч үзлийг сурталчилан “Хилчдийн нэг өдөр” уулзалтыг зохион байгуулах, урлаг соёлоор үйлчилэх | Жилдээ | 1 сая | Хилийн 0166 дугаар анги | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| 7 | Орон нутгийн засаг захиргаа, хууль сахиулах болон харилцан ажиллагаатай байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг тодотгох | Хагас жилд | - | Хилийн 0166 дугаар анги | |
| 8 | Баянхонгор аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажлын байранд дээрх сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж, анги салбарын бие бүрэлдэхүүнийг мэргэшүүлэх сургалт, дамжаанд хамруулах | Тухай бүр | - | Аймгийн ЗДТГ, Хилийн 0166 дугаар анги | |
| **Хоёр.Хил хамгаалалтын үр дүнг дээшлүүлэх ажлын хүрээнд:** | | | | | |
| 9 | Түншийн холбоог сайжруулж, хилийн застав, харуул, хилчдийн амьдрал ахуйтай танилцуулах, анги, застав, харуулын байрыг тохижуулах чиглэлээр хамтран ажиллах арга хэмжээг зохион байгуулах | Жилдээ | - | Аймаг, сумдын ЗДТГ, Хууль эрх зүйн хэлтэс, Хилийн 0166 дугаар анги | |
| 10 | “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн ажлыг зохион байгуулж дэмлэг үзүүлэх | Жилдээ | 15 сая | Аймаг, сумдын ЗДТГ | |
| **Гурав.Хилчдийн нийгмийн асуудлыг дээшлүүлэх ажлын хүрээнд:** | | | | | |
| 11 | Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилчдийн нийгмийн асуудлыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах | Жилдээ | - | Нийгмийн бодлогын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс | |
| 12 | Хилийн отряд, заставт ажиллаж буй албан хаагчид, Хугацаат цэргийн алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах, эрүүл мэндийн сургалт, үйлчилгээ зохион байгуулах | Жилдээ | - | Аймгийн Эрүүл мэндийн газар | |
| 13 | Орон нутгийн төр, захиргааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай харилцан ажиллах түншлэлийн холбоог тодотгох, хилийн застав, харуулыг бэхжүүлж, хилчдийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах | Жилдээ | - | Аймаг, сумдын ЗДТГ | |
| 14 | Хилийн 0112 дугаар салбарын бог малыг вакцинжуулалтад хамруулж, малыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах | Жилдээ | - | Хүнс, хөдөө аж ахуйн газар | |

50

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Дөрөв.Мэдээ, мэдээлэлийн ажлын хүрээнд хийгдэх ажил:** | | | | | |
| 15 | Улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж буй хүн, мал, автомашин, зэвсэг, техникийн талаар нэн даруй мэдэгдэж байх | Тухай бүр | - | Аймгийн Цагдаагийн газар, Тагнуулын газар | |
| 16 | ХХБ, отряд, заставуудын үйл ажиллагааг сурталчилах ажлыг сум, багуудад зохион байгуулах | Жилдээ | - | Аймаг, сумдын ЗДТГ, Хилийн 0166 дугаар анги | |
| 17 | Хил хамгаалах туслах хүчний гишүүний үүргээ сайн биелүүлж идэвхтэй оролцсон иргэдийг шагнаж урамшуулах | Жилдээ | - | Хилийн 0166 дугаар анги | |
| 18 | Хилийн застав, харуулыг хууль, тогтоомжийн эмхэтгэл, гарын авлага материалаар хангах, хуулийн зөвлөгөө өгөх | Жилдээ | - | Хууль, эрх зүйн хэлтэс | |
| **Тав.Хяналт шалгалтын хүрээнд хийгдэх ажил** | | | | | |
| 19 | Хил орчмын нутаг дэвсгэрт Монгол Улсын Хилийн тухай хууль, тогтоомжийг иргэн, аж ахуй нэгж, байгууллага хэрхэн сахин биелүүлж байгаад хяналт тавих, хилийн болон хил орчмын дэглэмийн биелэлтийг сахиулах зорилгоор хамтарсан хяналт, шалгалт явуулах | Жилдээ | - | БОАЖ-ын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Тагнуулын газар | |
| 20 | Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил гаргагчдад оногдуулсан хариуцлага, авсан арга хэмжээний талаарх тайлан мэдээллийг хүргүүлэх | Жилдээ | - | Аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар | |

........................oOo........................